



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:**

Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд 3

1.2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр: 3-3

Хоёр. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2.1.Хэлтсээс зохион байгуулсан ажил,үйлчилгээ..... 3-4

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл,нийгмийн баталгааг хангах

чиглэлээр 4-5

2.3 Тоон гарын үсэг 5-6

2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран
ажиллаж, хэрэгжүүлсэн ажил6-6

2.5 Хэлтсээс зохион байгуулсан шинэлэг ажил6-7

Гурав. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:..... 7-10

3.1. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд10-10

3.2. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:.....10-10

Дөрөв. ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ

ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР..... 10-12

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 12-12

Зургаа. ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:..... 12-13

Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР13-15

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР 15-15

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:16-17

Арав. ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:..... 17-19

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 19-22

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

2022.12.05

Алтай хот

Нэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлага болгон хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг **18 сум 88 багийн 58.400** гаруй иргэнд хүргэн ажиллаж байна.

1.2 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГазрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, улсын бүртгэгч 25, архивч 1, нярав, бичиг хэргийн ажилтан 1, ахлах нягтлан бодогч 1, архивч, мэдээллийн технологийн ажилтан 1 зэрэг нийт 33 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР /Зураг хавсралт-1/

2.1. Хэлтсээс зохион байгуулсан ажил:

➤ 2022 оны ХАСХОМ-ийг мэдүүлэх ёстой 28 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2022 оны 01 сарын 21-нд багтаан сүлжээнд бүрэн шивүүлж, баталгааны маягыг гаргуулан авч баталгаажуулан хадгалсан болно. Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар иргэдээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй. Хөрөнгө орлогоо мэдүүлэхээс татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй.

➤ 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авлаа.

➤ Тус аймагт 2022 оны 03 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ 15 ДУГААР ИХ НААДАМ"-ЫН "Гар бөмбөгийн аврага шалгаруулах тэмцээн"-д Эрэгтэй 18, Эмэгтэй 14 баг оролцсоноос "Улсын бүртгэлийн хэлтэс"-ийн Баатарсүрэн ахлагчтай, Угтахбаяр дасгалжуулагчтай эмэгтэй баг тамирчид амжилттай оролцож хүрэл медаль хүртлээ.

➤ Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь "Харилцан-Хүндэтгэе" аянд нэгдэж батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аяны ач холбогдлыг иргэдэд сурталчлан тусгай лого агуулсан хүрээ бэлтгэж хэлтсийн 33 албан хаагч фэйсбүүк хаягийн зургаа шинэчлэн байршуулж нөлөөллийн аянд нэгдсэн.

➤ Албан хаагчдын цагийн бүртгэлийн мэдээлэл цуглуулах ZKTeко аппликэйшн ашиглан суурин компьютерт суурилуулсан төхөөрөмжөөс нийт 15 албан хаагчийн гар, хурууны хээг устгаж зөвхөн нүүрээр таних мэдээлэл болон

гараар цагийн бүртгэлийг хөтлөж байна. Уг үйл ажиллагааг Аймгийн тагнуулын байгууллагатай хамтран зохион байгуулсан.

➤ Монголын Хуульчдын холбооны санаачилгаар жил бүрийн тавдугаар сарын 01-ний өдөр зохиогддог “Хуульчийн про боно өдөр” арга хэмжээнд хэлтсийн албан хаагчид оролцож Улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээ, мөн тоон гарын үсгийн талаарх мэдээ мэдээллийг сурталчлан давхардсан тоогоор 168 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

➤ Тус хэлтэс нь “Үндэсний бичигтэн хамт олон” болох томоохон зорилтыг дэвшүүлсэн. Тус ажлын хүрээнд “ХҮМҮҮН БИЧИГ ХҮН БҮРИЙН БИЧИГ” сэдвээр төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан 2 шаттай тэмцээнд амжилттай оролцон тусгай байр эзэлж Аймгийн Засаг даргын өргөмжлөл, 450.000 төгрөгний мөнгөн шагналаар шагнууллаа.

➤ “Төрийн хэмнэлтийн хууль”-ийн хэрэгжилтийг хангаж хэлтсийн гэрээт 2 албан хаагчийг хэлтсийн даргын Б/03, Б/06 тоот тушаалуудаар тус тус ажлаас чөлөөлсөн болно.

➤ Мөн хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, болон тулгамдаж буй асуудал, Аймаг орон нутгийн удирдлага, УБЕГ-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт **23** удаагийн онлайн хурал зохион байгуулсан байна. /Үүнд: Шинэ програм, тоон гарын үсэг, гадаад паспортын зураг авалт бусад цаг үеийн асуудлуудаар/

➤ Тус хэлтсийн албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” тарих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Алтай хотын Баянхайрхан багийн ард **50**ш, 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Солонго хороололын Цэцэрлэгт хүрээлэнд **60** ширхэг шар хуайс, хайлаасны суулгацыг тус тус тарив.

➤ 2022.11.21-ны өдөр Аймгийн агентлаг, газар, хэлтсийн дарга нарын шуурхай хурал “Өглөөний цай” арга хэмжээг зохион байгуулж, Хэлтсийн үйл ажиллагаа болон цаг үеийн ажлын бусад мэдээ, мэдээллийг танилцууллаа.

➤ Улсын бүртгэлийн хэлтсээс 2022.11.23-ны өдөр Монгол Улсад Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 82 жилийн ой, Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 13 жилийн ой, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан баярын хурал хийж албан хаагчдын дунд волейбол, орс таталт, дартсын тэмцээнийг зохион байгууллаа.

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:

➤ Хэлтсийн албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргаж, УБЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу шагнуулах албан хаагчдыг хамт олны хурлаар хэлэлцэн шагналын материалыг 2022 оны 05 сарын 17-ны өдрийн №458 тоотойр УБЕГ-т шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Энэ онд ХЗДХЯамны “Жуух бичиг”-ээр нийт **7** албан хаагч, УБЕГ-ын “Жуух бичиг”-ээр **2** албан тус тус шагнагдаж, шагналыг бүртгэлийн ажилтны өдрөөр гардуулан өглөө.

➤ Туслах аж ахуйн ямааны ноолуурын үнэ болох **490.000** төгрөгөөр “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан хэлтсийн албан хаагчдын 0-18 насны **69** хүүхдийг хүлээн авч, гарын бэлэг авч гардууллаа.

➤ Тус хэлтсийн Дэлгэр сумын улсын бүртгэгч Сандивын Буянтогтоход УБЕГ-ын даргын 2022 оны Б/219 тоот тушаалаар **500.000** төгрөгний тусламж олгосон.

➤ Мөн Жаргалан сумын улсын бүртгэгч Х.Нэргүйд **680.000** төгрөг, Дэлгэр сумын улсын бүртгэгч С.Буянтогтоход **680.000** төгрөгийг хэлтсийн албан хаагчид хандив цуглуулан өглөө.

➤ Мөн УБЕГ-аас өрнүүлсэн 2 хандивын аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж, нийт **870.000** төгрөгийн хандив цуглуулан хүргүүлсэн.

➤ Тог цахилгааны гэмтлээс шалтгаалан 5 ханатай гэр нь шатсан тус хэлтсийн Халиун сумын улсын бүртгэгчид туслах үүднээс хэлтсийн албан хаагчид **510.000** төгрөгийн хандив цуглуулан хүргүүлж, сэтгэлийн дэм өглөө.

➤ Улсын бүртгэгчээр ажиллаж байгаад гарсан Энхбаярын уран бүтээлийн “Эрдэнэсийн авдар” нэртэй зохиолын номыг хандив болгон албан хаагчид нийт 220.000 төгрөгөөр худалдан авсан.

➤ > 2022 оны 09 дүгээр сард "Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийн дагуу ковидоор өвчилсөн **6** албан хаагчид цалинтай чөлөө олгож, **34** албан хаагчыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах хэрэгсэлээр тогтмол хангасан. Хэлтсийн **22** албан хаагчийг эрт илрүүлгийн эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг, оношилгоо, иж бүрэн шинжилгээнд хамрууллаа.

➤ Албан хаагчдын мэдлэг боловсролыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тус хэлтсээс “Эрх зүй”-н мэргэжлээр суралцаж байгаа албан хаагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор / УБЕГ-ын даргын 2022 оны Б/165, Б/168, Б/177 тушаалаар Цогт, Гуулин, Хөхморьт сумдын улсын бүртгэгчид, хэлтсийн даргын 2022 оны Б/03, Б/04 тоот тушаалаар мэдээлэл технологийн ажилтан, нярав бичиг хэргийн ажилтан/ 2022 оны 04 сарын 04-ний өдрөөс 18-ны өдрүүдэд 14 хоногийн цалинтай чөлөө олгон суралцууллаа..

2.3 Тоон гарын үсэг:/ Зураг хавсралт -2/

➤ Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд тоон гарын үсэг олгох нээлтийн үйл ажиллагаа 05 сарын 02-ны өдөр онлайнаар болж уг арга хэмжээнд амжилттай оролцсон.

➤ Тоон гарын үсэгтэй холбоотой видео шторкыг Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Монгол Улсын начин Г.Гансүх нарыг оролцуулан хийж хэлтсийн цахим хуудас болон байгууллагын фэйсбүүк хаягт байршуулсан.

➤ “Тоон гарын үсэгээ авцгаая” нөлөөллийн аяны хүрээнд фэйсбүүк хаягийн профайл зургийн хүрээг шинээр хийж хэлтсийн албан хаагчдын фэйсбүүкийн нүүр зургийг сольсон.

➤ Мөн тоон гарын үсгийн ач холбогдол бүхий мэдээ мэдээллийг аймгийн төв талбайн дэлгэцээр байнга сурталчилж Улсын бүртгэлийн хэлтсээс Төрийн 52, хувийн хэвшлийн 41 байгууллагад ажлын хэсэг очиж ажиллан нийт 10100 гаруй иргэнд мэдээллийг хүргэсэн байна. Мөн тоон гарын үсэгтэй холбоотой ярилцлагыг фэйсбүүкийн лайв сурвалжлагаар 5 удаа хийж иргэдэд мэдээлэл өглөө.

➤ Тоон гарын үсгийн олголтын ажлыг эрчимжүүлэх үүднээс Аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 10-ны өдрийн А/282 тоот захирамжаар төрийн албан хаагчдын тоон гарын үсэг авах хуваарийг гарган аймгийн хэмжээний бүх төрийн албан хаагчдад тоон гарын үсэг олголоо.

➤ Аймгийн Засаг даргын 2022 оны 10 сарын 21-ны өдрийн 04 тоот албан даалгавраар Сумдын засаг дарга нарт иргэдийг тоон гарын үсэгт яаралтай хамруулах үүрэг чиглэлийг хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан даалгаврын хэрэгжилтийг хангах чиглэлээр Хэлтсийн удирдлагууд Алтай хотын захирагч А.Алтанхуяг, Ахмадын хорооны дарга, Шинэ-Алтай захын захирал, Сургуулийн захирлуудтай биечлэн уулзаж иргэдийг тоон гарын үсэгт хамруулах хуваарь төлөвлөгөө гарган хамруулж байна.

➤ Тус хэлтсээс “Нээлттэй өдөрлөг-ийг 2022 оны 10 сарын 15, 28-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж 2100 иргэнд тоон гарын үсэг олголоо.

➤ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэн Аж үйлдвэрийн сэргэлт, Хот хөдөөгийн сэргэлтэд хамрагдах “Алтайн

хөгжлийн гарц, шийдэл” сэдэвт малчны чуулган зөвлөгөөн 2022 оны 11 дүгээр сарын 18,19-ны өдөр Алтай хотод зохион байгуулагдаж энэ үеэр тус хэлтсээс 2000 гаруй малчдад тоон гарын үсгийг олгож ажиллалаа.

➤ УБЕГ-аас тоон гарын үсэг олгох зөөврийн төхөөрөмжийг 2022.11.15-ны өдөр олгосон бөгөөд Хаан банк, Аймгийн нэгдсэн зах, Ахмадын хороо, Прокурорын газар, Нэгдсэн эмнэлэг зэрэг газруудад ажиллаж нийт 500 гаруй иргэнд тоон гарын үсэг олголоо.

➤ 2022 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар нийт 14.338 иргэнд тоон гарын үсэг олгож 36,2%-тай байна.

➤ **2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн ажил: /Зураг хавсралт- 3/**

➤ 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 5-р хуралдаанаар тус хэлтсийн үйл ажиллагаа явуулж буй 580,2 м2 талбай бүхий 11 өрөө 3 үйлчилгээний заал бүхий барилгыг Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчөөс тус хэлтсийн мэдэлд шилжүүлэх асуудлыг хэлэлцэж, хэлтсийн эзэмшилд өглөө.

➤ Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран саатуулагдаж байгаа 1 иргэнд цахим иргэний үнэмлэх олголтын бүртгэл, 1 иргэний гэрлэлтийн үйл ажиллагааг зохион хамтран зохион байгуулж гэрчилгээ, батламжийг гардууллаа.

➤ 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “Улс тунхагласны 98 жилийн ой”-г тохиолдуулан “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын залуучуудын холбооны Говь-Алтай аймаг дахь салбартай хамтран зохион байгуулж 150 сурагчид иргэний үнэмлэхийг нь гардуулан өглөө.

➤ Аймгийн Засаг даргын санаачлагаар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэн Аж үйлдвэрийн сэргэлт, Хот хөдөөгийн сэргэлтэд хамрагдах “Алтайн хөгжлийн гарц, шийдэл” сэдэвт малчны чуулган зөвлөгөөнд тус хэлтэс хамтран ажиллаж сумдын малчдыг хуваарилан хүлээн авч байрлуулах, чиглүүлэх, мэдээ мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

➤ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Төрийн аудитын газар хамтран “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион байгуулсан “Аймгийн төрийн байгууллагуудын шилэн данс хөтлөлтийг шалгах сарын аян”-д тус хэлтэс 98,9 хувьтай шалгагдаж аймгийн ГХУСЗөвлөлөөс 2022.12.02-ны өдөр **1,000,000** төгрөгөөр шагнагдлаа.

➤ Тус хэлтсээс Залуучуудын хөгжлийн сарын аян, “Аз жаргалтай гэр бүл” нөлөөллийн ажлын хүрээнд АДБ-ийн Алтай чуулга, ГБХЗХГазартай хамтран 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдөр гал голомтоо бадрааж байгаа иргэн Б.Баярсайхан, Б.Үнэнбилэг болон “Гэрлэлтийн гэрчилгээ”-гээ ёслол төгөлдөр гардаж буй иргэн Б.Пүрэвдаш, Г.Билгүүн нарт хүндэтгэл үзүүлэн Гэр бүлийн андгайг гардуулж хүндэтгэл үзүүллээ.

2.5 Хэлтсээс зохион байгуулсан шинэлэг ажил: /Зураг хавсралт- 4/

Улсын бүртгэлийн байгууллагаас 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн иргэнээс үндэсний энгийн гадаад паспортын захиалга авахдаа цээж зураг шаардахгүйгээр тухайн хэлтсийн бүртгэгч өөрөө цээж зургаа авч бүртгэлийн системд оруулан үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

➤ Энэ ажлын хүрээнд тус хэлтсээс гадаад паспортын зураг авах өрөөг 2022.10.10-ны өдөр өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тохижуулж иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.

➤ 2022.10.13-ны өдөр Аймгийн Шуудангийн Үйлчилгээний газрын удирдлагатай уулзаж Улаанбаатар хотоос аймгийн төвд гадаад паспортын

татан авалтыг долоо хоногт 3 удаа татан ирүүлэх асуудлыг шийдвэрлэн, ирсэн паспортыг иргэдийн гарт нь хүргэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар тус хэлтэст зургийг нь аван захиалсан үндэсний энгийн гадаад паспортын талаар иргэдээс ямар нэгэн гомдол санал ирээгүй байна.

Гурав: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

/Зураг хавсралт-5/

Тус хэлтсийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зэрэг ажлуудын хүрээнд 2022 онд явагдах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион явуулж байна.

3.1. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалт

Танхимаар зохион байгуулсан сургалт:

➤ 2022 оны 04 сарын 14-15-ны өдрүүдэд Цахим гарын үсгийн тухай хууль, түүнтэй холбоотой дүрэм журмыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, програм хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх сургалтанд Улсын ахлах бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтан нар

➤ 2022 оны 04 сарын 14-15-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын бодлого төлөвлөлт, дотоод үйл ажиллагааг шуурхай, нэгдсэн удирдлагаар хангах, цаг үеийн нөхцөл байдлын талаар санал, мэдээлэл солилцох үүрэг чиглэл, зөвлөмж өгөх сургалтанд хэлтсийн дарга тус тус хамрагдсан.

Онлайнаар зохион байгуулсан сургалт:

➤ 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Жэндэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх зүйлийн хэрэгжилтийг хангах онлайн сургалтанд хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц

➤ 2022 оны 01 дүгээр сарын 20-нд Удирдах ажилтны мэргэшүүлэх сургалт онлайн сургалтанд хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц

➤ 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Авлигатай тэмцэх газраас нийтийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан онлайн сургалт Н.Золжаргал Г.Баасанжаргал Б.Тогтохбаяр Д.Алтанцэцэг нар

➤ 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагын Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтанд Э.Баатарсүрэн Э.Цэрэндулам С.Баянаа нар

➤ 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах онлайн сургалтанд бүх алба хаагчид

➤ 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр “Шударга байдлын үнэлгээний дүн танилцуулах” онлайн сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц

➤ 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих Б.Энхзаяа нар

➤ 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Хүлээлтэд нийцсэн гүйцэтгэлийг тодорхойлж өгөх нь” сэдэвт сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц

➤ 2022 оны 03 дугаар сарын 22-ны Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад зориулсан эрх зүйн онлайн сургалтанд бүх албан хаагчид

➤ 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх онлайн сургалт бүх алба хаагчид

➤ 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс 06 дугаар сарын 14-ны өдөр хүртэл болох “Мэдэгтүн Сахигтун” онлайн сургалтанд Халиун сумын улсын бүртгэгч С.Чинзориг

➤ 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдөр тоон гарын үсэг нэвтрүүлэхтэй холбоотой сургалтанд Иргэний бүртгэлийн улсын бүртгэгч нар

- 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Хүмүүн байхын учир” онлайн сургалтанд 25 улсын бүртгэгч нар
- 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдөр ХЭУБГ-с эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч нарт зориулсан сургалт Б.Энхзаяа
- 2022 оны 07 дүгээр сарын 01-ны өдөр Able программын талаарх сургалт Э.Цэрэндулам
- 2022 оны 08 дугаар сарын 31-ны өдөр Үндэсний энгийн гадаад паспорт зураг авах сурах гэрэл зургийн сургалтанд Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Б. Тогтохбаяр Э.Түвшинзаяа
- 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Албан хаагчдад зориулсан E-doc системийн сургалтанд 15 албан хаагч
- 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Удирдах албан тушаалтанд зориулсан E-doc системийн сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц
- 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Албан хаагчдын хууль эрх зүйн, практик хэрэглээг нэмэгдүүлэх цахим сургалтанд бүх албан хаагчид
- Гадаад паспортын гэрэл зураг авах гэрэл зургийн сургалт Б.Тогтохбаяр Э.Түвшинзаяа нар
- 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдөр Авлигын эсрэг анхан шатны сургалтанд бүх албан хаагч
- 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны явцад хяналт тавих журмын танилцуулга сургалтанд Д.Оюунчимэг Б.Энхзаяа нар
- 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Хяналт шалгалт зөрчлийн нэгдсэн сан программын танилцуулга сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг
- 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Хүний эрхийг хангах болон хүн худалдаалахтай тэмцэх урьдчилан сэргийлэх холбоотой хууль тогтоомжийн талаарх сургалтанд бүх албан хаагчид
- 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдөр Еранхийлөгчийн дэргэдэх хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газраас хамтран зохион байгуулж буй архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд хамрагдах сургалтанд Э.Баатарсүрэн С.Баянаа Э.Цэрэндулам нар
- 2022 оны 10 дугаар сарын 25-ны Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтанд 22 албан хаагч
- 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн албан хаагчдад зориулсан дотоод сургалтанд 30 албан хаагч
- 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “Хөдөлмөрийн дотоод журам”-ын шинэчилсэн найруулгын талаарх сургалтанд 30 албан хаагч
- 2022.10.28-нд УБЕГазрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас анхан шатны баримт бүрдүүлэлт, анхан шатны баримтын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргахад анхаарах асуудлын талаар харилцан туршлага солилцох талаар зохион байгуулсан онлайн сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц, Ахлах ня-бо Б.Алтанбагана, Нярав, бичиг хэргийн ажилтан Э.Цэрэндулам
- 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Аймгийн улсын бүртгэлийн Хэлтсийн дарга Ахлах нягтлан бодогч нар оролцох цахим сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц Ахлах нягтлан бодогч Б.Алтанбагана нар
- 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн албан хаагчдад зориулсан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтанд Хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар

➤ 2022.11.30-ны өдөр УБЕГ-ын даргын 2022 оны 11 сарын 15-ны 1/9891 тоот чиглэлийн дагуу Жендерийн үндэсний хорооны сайтад байршсан “Төрийн албаны удирдах албан тушаалтанд зориулсан жендерийн цахим сургалт”-нд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц тус тус хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт:

➤ 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Аз жаргалтай ажиллахын нууц” сэдэвт сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид

➤ 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Улсын их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал зохицуулах харилцааны талаар” онлайн сургалт бүх алба хаагчид

➤ 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Орчин үеийн мегатрэндүүд” онлайн сургалтанд 11 албан хаагч

➤ 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол орны хөгжлийн хэтийн хөтөлбөр” онлайн сургалтанд 18 алба хаагч

➤ 2022 оны 03 дугаар сарын 24-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Алдаа дутагдлыг шийдвэрлэх” онлайн сургалтанд 22 албан хаагч

➤ 2022 оны 04-р сарын 07-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих” онлайн сургалтанд 25 албан хаагч

➤ 2022 оны 04-р сарын 14-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Чанарын менежментийн тогтолцоо ” онлайн сургалтанд 6 албан хаагч

➤ 2022 оны 04-р сарын 21-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих” онлайн сургалтанд 11 албан хаагч

➤ 2022 оны 04-р сарын 28-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга, онцлог зохицуулалт” онлайн сургалтанд 26 албан хаагч

➤ 2022 оны 05-р сарын 05, 12-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил ” онлайн сургалтанд албан хаагчид

➤ 2022 оны 05-р сарын 19-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэлийн эхлэл” сэдэвт онлайн сургалтанд 19 албан хаагч

➤ 2022 оны 06-р сарын 02-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “20 дугаар зууны Монгол Улсын гадаад харилцааны тойм” сэдэвт онлайн сургалтанд 4 албан хаагч

➤ 2022 оны 06-р сарын 09-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх” сэдэвт онлайн сургалтанд 15 албан хаагч

➤ 2022 оны 06-р сарын 13-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн алба- шинэ сорилтууд” сэдэвт онлайн сургалтанд 9 албан хаагч

➤ 2022 оны 10-р сарын 13-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Цахим сургалтын бүртгэл, техникийн тестлэлт” сэдэвт онлайн сургалтанд 15 албан хаагч

➤ 2022 оны 11-р сарын 03-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Стресс менежмент” сэдэвт онлайн сургалтанд 28 албан хаагч

➤ 2022 оны 11-р сарын 17-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр” сэдэвт онлайн сургалтанд 14 албан хаагч

➤ 2022 оны 12-р сарын 01-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” сэдэвт онлайн сургалтанд 18 албан хаагч тус тус хамрагдлаа.

3.2. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалт:

➤ 2022 оны 05 сарын 19-ны өдөр Цахим хөгжил харилцаа холбооны яам, E-Mongolia академийн хамтарсан баг цахим засаглалын ерөнхий ойлголт, тоон гарын үсэг ба түүний хэрэглээ, цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга зэрэг сэдвүүдээр төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтанд хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан, нярав бичиг хэргийн ажилтан, хуулийн этгээдийн улсын бүртгэгч, Есөнбулаг сумын улсын бүртгэгч нийт 4 албан хаагч

➤ 2022 оны 05 сарын 27-ны өдөр Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтанд хэлтсийн архивч, бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан нар

➤ 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Архивын шинэ хуулийн талаарх сургалт болон албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтыг А С.Мөнхжаргал Э.Ичинхорлоо нар тус хэлтсийн албан хаагчид хамрагдсан.

➤ Аймгийн Соёлын хэлтсээс 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Цус ойртолт, Угийн бичиг хөтлөх” сэдэвт сургалтанд хэлтсийн 18 албан хаагч

➤ 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албанаас “Төрийн албан хаагчдын үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах, турших” сургалтыг зохион байгуулсан. Тус хэлтсээс С. Баянаа Э.Баатарсүрэн Э.Цэрэндулам нар хамрагдлаа.

3.3. Хэлтсээс зохион байгуулсан сургалт:

➤ 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсээс “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар” онлайн сургалт зохион байгуулж төрийн захиргааны 26 албан хаагч

➤ Тус хэлтсээс Монгол Улсын Их Хурлын 2022 онд шинээр баталсан болон өөрчлөлт орсон хуулиудаар 2022.10.26,27-ны өдөр зохион байгуулсан цахим сургалтанд 23 албан хаагч

➤ 2022.11.23-ны өдөр зохион байгуулсан хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтанд 30 албан хаагч тус тус хамрагдлаа.

Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР: /Зураг хавсралт-6/

Цахим хаяг: <https://govi-altai.burtgel.gov.mn/>

Фэйсбүүк хаяг: /Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс/

Фэйсбүүк хаяг: [/GAA-n UBHeltel/](#) /байгууллагын албан хаагчид зөвхөн орох, дотоод албан бичиг, мэдээ мэдээлэл солилцох/:

Вэб хуудасны хөгжүүлэлт:

- Хуудасны баннер цэсийг нэгдсэн загварт оруулж холбогдох линкийг холбосон.
- Албан хаагчдын мэдээлэл, газар орны мэдээллүүдийн өөрчлөлтийг тухай бүр нь шинэчлэсэн.
- Вэб-д оруулах бүх цэсэнд тохирсон мэдээллүүдийг хугацаанд нь байршуулсан.

- Вэб-д оруулсан мэдээллийн линкийг байгууллагын фэйсбүүк хаягаар дамжуулан байнга сурталчилан ажилласан.

Вэб хуудасны ангилал	Оруулсан мэдээний тоо
Санхүүгийн ил тод байдал	36
Хурал, сургалт семинар, хэлэлцүүлгийн зар	17
Жил улирлын тайлан	10
Нээлттэй ажлын байрны зар	0
Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал	19
Сар бүрийн тоон мэдээлэл	29
Түгээмэл асуулт хариулт	23
Цаг үеийн мэдээ	107
Видео мэдээ	39
Топ мэдээ	31
Нийт байршуулсан мэдээ	311

Сурталчилгааны чиглэлээр:

➤ Байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн цахим хуудас, фэйсбүүк хаяг болон аймгийн телевиз радиогоор болон үйлчилгээний зааланд байрлуулсан LCD зурагтаар дамжуулан иргэдэд түргэн шуурхай мэдээллэх арга хэмжээг авч ажиллаж байна.

➤ Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, тоон гарын үсэгтэй холбогдуулан “live сурвалжлага “ 5 удаа хийж иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн байна.

➤ Бүртгэлийн үйлчилгээний үнэ тариф, бүрдүүлэх нотлох баримт бичиг, үйлчилгээний хөлс тушаах дансны мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх улсын бүртгэгчийн мэдээлэл, үйлчилгээ авах цэг, хаяг байршлыг агуулсан самбарыг үйлчилгээний танхимд байршууллаа.

Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ийн дагуу үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

➤ Албан хаагчдын компьютерийн плаш оролтуудыг бүрэн хааж, аюулгүй байдлын санамжийг компьютер болгон дээр наасан.

➤ Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг 14 хоногоос 1 сарын дотор солиулж, бүртгэл хөтлөн ажиллаж байна.

➤ Хэлтсийн архив, сүлжээ сервер болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлчилгээний заал, коридор, архивын гадна дотор хаалга, сургалтын заал зэрэгт 5 камер байрлуулан ажиллаж байна.

➤ Үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютер, процессорыг эрсдэлээс урьдчилан “УБЕГ” лацаар лацдаж бүртгэл хөтөлсөн.

➤ Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагддаг 9 компьютерийг BITDEFENDER вирусны жилийн лицензтэй програмаар хамгаалсан.

➤ Тог цахилгааны эрсдэлээс сэргийлэн УБЕГ-аас хэлтэст ирүүлсэн 11 ширхэг тог тогтворжуулагчийг тогны асуудалтай сумд болон хэлтсийн сервер, үйлчилгээний заал, нэг цонхонд байршуулан ашиглаж байна.

➤ Мөн серверийн өрөөний цэвэрлэгээ арчилгааг стандартын дагуу хийж ажиллаж байна.

Сервер, компьютер тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ:

➤ Тайлант онд хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер тоног төхөөрөмжинд УБЕГ-аас парк шинэчлэл хийгдэж сүүлийн үеийн компьютер тоног төхөөрөмжөөр хангагдсан тул эвдрэл гэмтэл засвар үйлчилгээ хийгдээгүй болно.

➤ Харин хэлтсийн серверийн рөүтерийг МТГ-аас Sophos router-ээр шинэчлэсэн бөгөөд тохиргоог заасан хугацаанд нь хийлгүүлж, ашиглаж эхэлсэн. Одоогоор үйл ажиллагаа хэвийн жигд явагдаж байна.

➤ Хэлтсийн төв сервер болон Нэг цэгийн үйлчилгээний газрын сүлжээний дамжуулагч Converter /нийт 4 ширхэг/-уудыг өөрсдийн бололцоонд тулгуурлан бүрэн шинэчлэсэн.

➤ Байгалийн хүчтэй шуурганы улмаас Эрдэнэ сумын шилэн кабель тасарч, тогны хэлбэлзлээс шалтгаалан дамжуулагч конвертор, рөүтерийн тэжээлийн залгуур зэрэг шатсаныг аймгийн МХСүлжээний газартай хамтран томилолтоор ажиллан гэмтлийг шуурхай засварлаж ажилласан.

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлант хугацаанд тус хэлтсээс **1049** албан тоотыг явуулснаас хууль хяналтын байгууллагад 400, Аймгийн ЗДТГ, ИТХ-д 50, УБЕГ-т 302, /үүнээс тоон гарын үсгээр баталгаажуулж 30 бичиг хүргүүлсэн/ бусад албан байгууллага аймаг руу 297 албан бичгийг тус тус хүргүүлсэн байна. Мөн 152 бичиг ирсэн. Үүнд: Хууль хяналтын байгууллагаас 24, Аймгийн ЗДТГ, ИТХ-аас-13, УБЕГ-аас 42, бусад байгууллагаас 73 бичиг ирсэн байна.

Тайлант хугацаанд хэлтэст 475 хариутай бичиг ирснээс Хууль, хяналтын байгууллагаас 384, аймгийн ЗДТГ, ИТХ-аас 21, УБЕГ-аас 20, бусад байгууллагаас 50 албан бичиг ирсэнийг холбогдох албан хаагчид даргын цохолтоор хүргүүлж 100 хувь шийдвэрлэсэн. Хэлтэст Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 3, Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 71 нийт 74 өргөдөл ирсэнээс 64 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. 10 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байгаа талаар батлагдсан маягт, хүснэгтийн дагуу нэгтгэж тайлан мэдээг УБЕГ болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд хэлтсээс явуулж байгаа баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулж, хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдол, хариутай бичиг, албан тоотыг бүртгэлийн дэвтэрт бүртгэж office.govi-altai.gov.mn мөн Able буюу программ ашиглан, хяналтын картаар холбогдох албан хаагчдад танилцуулж хариуг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

2022 онд тус хэлтсийн сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Зургаа. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлант хугацаанд 12-р сарын 01-ны байдлаар төрсний бүртгэл-940, гэрлэлт-183, үрчлэлт-24, эцэг тогтоолт-39, овог нэр нэр өөрчлөлт-48, нас баралт-285, гэрлэлт цуцлалт-16, иргэний үнэмлэх шинээр болон дахин-2429, бусад аймаг хотоос шилжин ирсэн 199 иргэний, аймаг доторх шилжилт хөдөлгөөний бүртгэлээр-666 иргэний бүртгэл хөтлөж, бүртгэл тус бүрийн хуульд заасан нотлох баримт 8840 хуудсыг цахимжуулсан.

Үндэсний энгийн гадаад паспорт авах-508 иргэний хүсэлтийг хүлээн авч зургийг улсын бүртгэгч нар 09 сарын 30-ны өдрөөс эхлэн авч засварлан баталгаажуулж Иргэний Улсын бүртгэлийн газарт илгээж хэвлэгдэн ирсэн гадаад паспортыг иргэдэд олгож 139 хуудас баримт цахимжуулсан.

Гадаад паспортын зураг авах чиглэлээр УБЕГ-аас зохион байгуулсан 3 удаагийн сургалтанд хамрагдсан.

УБЕГ-ын ИБГ-аас тус аймгийн харьяат иргэний мэдээллийн санд зөрүүтэй 185 иргэний нэрийн жагсаалт ирүүлснээс архивын сангаас Б талыг татан авч тулган шалгаж, ИУБ-11-ИУБ-14 маягт- нийт 200ш маягт цахимжуулж, зөрчилтэй материалыг жагсаалтаар Хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж засуулсан.

Архив, лавлагаа олголт: Иргэд болон албан хэрэгцээнд зориулж 3905 лавлагаа олгосноос иргэдэд 2370, хууль хяналтын байгууллагын албан тоотоор 1107, албан хэрэгцээнд 544 лавлагааг тус тус олгож, иргэний баримтын архивын хувийн хэргийн санд 679 иргэний хувийн хэргийг шинээр үүсгэж, ИУБ-11,ИУБ-18 маягт 5492 төрөлжүүлэн байршуулж, бусад аймаг хотруу шилжин явсан 369 хувийн хэргийг ялган шилжүүлж, аймаг хотоос шилжин ирсэн 171 иргэний хувийг хэргийг галиглан байршуулсан.

Хууль хяналтын байгууллагын 240, УБЕГ 60, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 50, бусад аймаг нийслэлийн УБХэлтсийн 200 албан бичгээр архивын лавлагаа, хуулбар, хувийн хэрэг, ХУБ дүгнэлтээр засвар өөрчлөлт хийх хүсэлтийг шийдвэрлэж хүргүүлэн ажилласан. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлтийн 6 бүртгэлд засвар хийсэн.

Долоо.ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2022 онд иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн **3205** мэдүүлэг хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд 100% шийдвэрлэв. Үүнд: газраас бусад үл хөдлөх хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 97, шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийн 82, төрөөс худалдаж авсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 1, төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн 188, газар эзэмших эрх өмчлөх эрх болж өөрчлөгдөх бүртгэл 1, худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 282, бэлэглэх гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 136, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 59, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 35, албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх 6, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээгээр шинэ бүртгэл үүсэх 64, эрх бүхий этгээдийн шийдвэрээр өмчлөх эрх шилжих 1, бусад хэлбэрээр өмчлөх эрх шилжих бүртгэл 1, барьцаат зээлийн гэрээний 1234, барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгох 850, шаардах эрх шилжүүлэх 1, лавлагаа хуулбар олгох 3, бүртгэлд өөрчлөлт оруулах 145, түрээсийн гэрээний 1, гээгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 12, бүртгэл хаах 6 бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэлээ.

Нийт бүртгэлийн тоо /өссөн дүнгээр/ газраас бусад үл хөдлөх хөрөнгө 5290, газар 4870 бүртгэгдсэн байна.

Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар иргэн, хуулийн этгээдээс 28.196.740 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 1.570.621 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварын орлого 151.481.832 төгрөг тус бүрийг улсын болон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.

Мэдээ тайлан, судалгаа

Цахим мэдээллийн санд оруулсан засвар өөрчлөлтийн 3,4,5,7,8,11-р сарын тайланг хугацаанд нь ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

Бүртгэлийн тоон мэдээ, үнэт цаасны болон улсын тэмдэгтийн хураамжийн тайланг тухай бүр хугацаанд нь нэгтгэн тайлагнасан.

ГХБХБГазарт газар эзэмшил ашиглах эрхийн талаарх мэдээлэл судалгааг удаа гаргаж хүргүүлсэн.

Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг 2 удаа УБЕГазарт хүргүүлсэн.

Татварын хэлтэст шинээр бүртгэгдсэн болон хаасан бүртгэлийн судалгааг 1 удаа, 2 хуулийн этгээд 2 иргэний 18 ҮХХ-ийн лавлагааг жагсаалтаар 2 удаа гаргаж хүргүүлсэн.

Сумдын бүртгэгч нэрын ЭХЭУБүртгэл хийсэн болон улсын бүртгэгчдийн судалгааг ЭХЭУБГазарт хугацаанд нь гаргаж тайлагнасан.

Улсын бүртгэлийн архивын газарт төрийн болон бусад байгууллагад олгосон лавлагаа, судалгааг жагсаалтаар гаргаж хүргүүлсэн.

Мэдээлэл сурталчилгаа бусад ажил

Аймгийн ГХБХБГазар, ШШГГазар, Нотариатууд, Татварын хэлтэс, Банкуудтай мэдээлэл солилцож хамтран ажиллалаа.

1-р сард онлайнаар сумдын бүртгэгч нарт хаягжуулалт болон газрын бүртгэлийн талаар мэдээлэл хийсэн.

Төрийн албаны зөвлөл болон УБЕГ-аас хийсэн 8 удаагийн, АТГ-ын 4 удаагийн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 3 удаагийн цахим сургалтанд тухай бүр тасгийн албан хаагчид бүрэн хамрагдсан.

3-р сард аймгийн төвийн сум болох Есөнбулаг сумдын ЗДТГ, багийн дарга нийгмийн ажилтан нартай болон ГХБХБГазрын хаягжуулалт хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзалт хийж хаягжуулалт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүртгэлийн явцад тулгамдаж байгаа асуудлаар мэдээлэл хийж, санал солилцож хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.

Барьцааны эрхийн бүртгэлийн хүсэлтэнд өөрчлөлт орж загвар маягт шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан аймгийн төвийн банкууд, ББСБ, ХЗХоршоонд зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажиллаж эхэллээ.

Аймгийн Архивын газраас хийсэн хууль тогтоомжийн сургалт, Аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс хийсэн монгол хэлний дүрмийн сургалт, ургийн бичгийн сургалтуудад бүртгэгч нар бүрэн хамрагдсан.

2 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг, 1 удаагийн “Хуульчдын про боно өдөрлөг”-т идэвх санаачлагатай оролцож иргэдэд мэдээ мэдээлэл хүргэж ажилласан.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг” монгол хэлний олимпиадын 1,2-р шатанд, монгол хэл бичгийн шалгалтанд амжилттай сайн оролцсон.

Үүрэг даалгаврын биелэлт:

Чандмань, Эрдэнэ, Дарив, Тонхил, Алтай,Цээл, Баян-Уул, Хөхморьт, Халиун, Бигэр сумдын иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж нийт 167 бүртгэл хийсэн байна.

Цахим санд 634 бүртгэлийн 137 зөрчилтэй алдаатай мэдээлэл нотлох баримтанд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн засвар өөрчлөлт оруулж залруулж холбогдох тайланг тухай бүр ЭХЭУБГ болон БХГазарт хүргэсэн.

“ЭХЭУБүртгэлийн цахим санд эрхлэн хөтлөх журам”-ын төсөлд 5 санал, ЭХЭУБтХуулийн болон “ЭХЭУБүртгэл хөтлөх журам”-ын төсөлд 3 санал боловсруулж ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын тушаалаар ЭХЭУБГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу Чандмань, Алтай сумдын газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 182ш хувийн хэргийн 449 үйлчилгээний 4876ш хуудас нотлох баримтыг нягтлан шалгаж үзлэг хийж тэмдэглэлийг илтгэх хуудсын хамт ЭХЭУБГазарт хугацаанд нь хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын А/427 тоот тушаал, ЭХЭУБГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу барьцааны эрхийн бүртгэлийн талаар аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ, ХЗХоршоонд албан бичиг загвар маягтын хамт хүргүүлж хэрэгжүүлэн ажиллаж байна.

3-р сарын 15-ны өдрөөс 7-р сарын 10-ны хооронд архивын 9899ш хувийн хэргийн цаасан баримтыг цахим сантай тулган шалгаж, тоолж, ш тусгаарласан хуудсыг ялгаж устгалд оруулах нэрийн жагсаалтад оруулж, алдаатай зөрчилтэй мэдээллийг засвар өөрчлөлт хийж засаж байна.

11-р сард ЭХЭУБГазраас өгсөн 6/9582 тоот үүрэг чиглэлийн дагуу 32 газраас бусад үл хөдлөх хөрөнгө, 31 газрын үнийн мэдээлэл дутуу, 528ш газрын 720 барьцаалагч буруу дутуу оруулсан алдаатай мэдээлэл, 1248ш газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 2007 барьцаалагч буруу дутуу цахимжуулсан, боловсруулалтанд дутуу оруулсан алдаатай мэдээллийг засаж тайлан, илтгэх хуудсыг хүргүүллээ.

Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 199 иргэн хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой лавлагаа олгож, 6 шүүхийн шийдвэрийн дагуу архивын нотлох баримтын хуулбар гаргаж, 6 шүүхийн шийдвэрийн дагуу лавлагаа олгож, 22 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрх түдгэлзүүлсэн тусгай тэмдэглэл бүртгэж, 16 эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээсэн бүртгэл хийж, МИК-ийн 5 албан бичгийн дагуу 92 үл хөдлөх хөрөнгийн хөрөнгийн багц дахь тусгай тэмдэглэл бүртгэж, бусад төрийн байгууллагын албан бичгийн дагуу 6 лавлагаа мэдээлэл гаргаж тухай бүр хугацаанд нь хариу хүргүүллээ.

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлангийн хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, 2022 оны 12 сарын 01-ны байдлаар нийт 1807 иргэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд - 112

Хязгаарлагдмал хариуцлагатай компани -183

Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/ - 19

Нөхөрлөл - 27

Хоршоо - 9

Төрийн байгууллага албан газар - 1

Холбоо - 17

Үйлдвэрчний эвлэлийн байгууллага - 3

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт – 283

Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдсөн-87

Хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөн-2

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон - 152

Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон -41

Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл - 23 тус тус бүртгэсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасаны дагуу

Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулах 6 хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны а/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдтийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас 189 олгож, хуулийн этгээдийн 87 тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон.

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

Шинээр нээсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 195, газар өмчлөх эрхийн 138 хувийн хэрэг нийт 330 хувийн хэрэг архивт хүлээн авч бүртгэл хөтлөн байршуулсан.

3215 хувийн хэргийн эх нотлох баримтыг бүртгэгч нараас хүлээн авч хувийн хэргийн баяжилт хийсэн.

2022 оны 12 сарын 02 байдлаар тус архивт газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 5372 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 4869 хувийн хэрэг, хадгалагдаж байна.

Одоогийн байдлаар тус архивт байнга хадгалах бүртгэлийн дэвтэр 209 х/н, түр хадгадагдах 142 дэвтэр хадгалагдаж байна. Эд хөрөнгийн бүртгэлийн архивийн хувийн хэргийн тооллогыг хийж хувийн хэргийг цахимжуулах явцад тусгаарласан 63.279 хуудас нотлох баримтыг хувийн хэргээс ялган авч нягтлан шалгасан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн архивт 2022 оны 12 сарын 01-ны байдлаар анхны бүртгэлийн 188 хувийн хэрэг шинээр хүлээн авч, бүртгэн архивт байршуулсан. Үүнд: Нөхөрлөл 27, Холбоо 17, НҮТББ 17, ГҮТББ 2, Хоршоо 8, ХХК 112, ХЗХ 1, ОНӨААТҮГ 1, ҮЭБ 3, тус тус бүртгэгдсэн байна. Татан буугдсан 23 хуулийн этгээд, шилжин явсан 2 хуулийн этгээд бүртгэж тус архивт нийт 1480 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хувийн хэрэгт 232 эх нотлох баримтыг хүлээн авч хувийн хэрэгт байрлуулсан.

Иргэний улсын бүртгэлийн архив:

Тус архивт 12 сарын 01-ны байдлаар 5492 ширхэг ИУБ маягт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан сан тус бүрт байрлуулсан. Үүнд: ИУБ-11 маягт 758, Иуб-12 маягт 17, Иуб-13 маягт 41, Иуб-14 маягт 33, Иуб-15 маягт 140, Иуб-16 маягт 12, Иуб-18 маягт 246, Иуб-31 маягт 2297, Иуб-21 маягт 1948 ширхэгийг тус тус хүлээн авсан.

2022 онд шилжин явсан 369 иргэний хувийн хэргийг архивын сангаас татан авч харъяа газарт нь хүргүүлсэн.

Шилжин ирсэн 171 иргэний хувийн хэргийг хууль журмын дагуу хүлээн авч бүртгэл хөтлөн цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан архивт байрлуулсан.

2021 онд бүртгэл хийхэд бүрдүүлсэн ИГБББ-ийн анхан шатны баримт болон бүртгэлийн дэвтэр 112 хадгаламжийн нэгжийг хүлээн авч бүртгэн ИГБББ-ийн санд байрлуулсан.

“ ИГБББ сан”д нийт 1406 хадгаламжийн нэгж ,

“ Хувийн хэргийн сан”д 42902 иргэний 168740 ширхэг хаатр маягт,

“ Нас баралтын сан”д 11597 иргэний 57780 ширхэг хаатр маягт,

“ Хаатр 11 сан”д 21351 иргэний 24878 ширхэг хаатр маягт,

Мөн үндсэн мэдээллийн санд бүртгэлгүй 1648 иргэний 3296 ширхэг маягт, мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 3283 иргэний 6270 ширхэг маягт, регистрийн дугаар хүчингүй төлөвтэй 792 иргэний 1400 ширхэг маягт нийт иргэний баримтын архивт 81573 хадгаламжийн нэгж 262364 ширхэг хаатр маягт хадгалагдаж байна.

Мөн 232 иргэний хүсэлтээр архивын баримтнаас төрөлт, гэрлэлт, нас баралтын лавлагаа шүүсэн.

Хадгалалт хамгаалалт :

Архивын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 9 заалт бүхий төлөвлөгөөг гарган баталж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд:

- Эд хөрөнгийн бүртгэлийн архивын хувийн хэргийн тооллогыг Хэлтсийн даргын 2022 оны 03 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг хийж дуусгалаа.

- Хуулийн этгээдийн архивт 6 төмөр тавиур нэмж өргөтгөн хувийн хэргийг байршууллаа.

-Иргэн, Эд хөрөнгийн архивыг өргөтгөн 7 ш төмөр тавиурыг байршуулж, архивын коридорт 1ш хяналтын камер суурилуулсан.

Мөн архивын цонхны хөшгийг стандартын дагуу хийж галын аюулаас хамгаалах багаж хэрэгслүүдийг шинэчлэн, галын мэдрэгч байршуулсан.

-2022 онд Улсын бүртгэлийн архивын газарт хандан 10 ширхэг архивын тавиурын асуудлыг шийдвэрлүүлсэн. Архивчийн ажиллах таатай орчныг бүрдүүлж, хэлтсийн зүгээс ажиллах нөхцөл боломжийг хангаж 2 давхарт тусд нь өрөө тохижуулж өгсөн ба албан хэрэгцээнд суурин компьютер, гурван үйлдэлт принтер, мөн архивын санд дотоод сүлжээ ашиглаж мэдээллийн сангаас хувийн хэрэг тулган шүүх боломжтой нэг суурин компьютерийг суурилуулж өгсөн.

Бусад ажлууд:

Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хувийн хэргийн мэдээг сар бүр гаргаж УБТА-т хүргүүлсэн.

УБЕГ-ын УБТАрхиваас ирсэн чиглэлийн дагуу устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн байгууллагын ББНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж санал хүргүүлсэн. Архивын баримтын тоо бүртгэлийг хөтлөж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалт, ХХНЖ зэргийг гарган ББНШК-ын хурлаар батлуулав. 2021 онд устгахаар ялгасан баримтуудыг УБЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу устгаж акт үйлдэн УБТАрхивт хүргүүлсэн.

Арав. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлангийн хугацаанд Хяналт шалгалтын ажлын 10 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын лавлагаа олгосон бүртгэлд өдөр тутмын хяналт тавьж ажиллаж байна. Мөн төлөвлөгөөт шалгалтыг 4 удаа, төлөвлөгөөт бус шалгалтыг 1 удаа, өргөдөл, санал, гомдлын мөрөөр 46 удаагийн шалгалт хийсэн.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 2422 бүртгэлд хяналт тавьж, 733 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн 1052 бүртгэлд хяналт тавьж, хяналт шалгалтаар илэрсэн 213 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа. Төрсний, гэрлэсний, үрчилсний, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний, эцэг тогтоосны, нас барсны, биеийн давхцахгүй өгөгдлийн, регистрийн дугаарын, шилжилт хөдөлгөөний болон архивын лавлагаа олгосон нийт 2035 бүртгэл, иргэний үнэмлэхийн 387 бүртгэлийг шалгасан. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хурууны хээ зөрсөн, давхардсан 43, төрөлт, гэрлэлтийн 3 бүртгэлийг тус тус хүчингүй болгосон.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 773 бүртгэлд хяналт тавьж, 390 бүртгэлийн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цахимжилтын явцад эд хөрөнгийн хаяг буруу, дутуу оруулсан, барьцаалагчийг буруу оруулсан, зурган мэдээлэл ороогүй, бүртгэлийн төрлийг буруу сонгосон, огноог буруу оруулсан, үнэ бичээгүй, өмчлөгчийг буруу, дутуу оруулсан, үйлчилгээний төрлийг буруу сонгож цахимжуулсан, зурган мэдээлэл харагдахгүй байгаа, давхардуулсан, дутуу цахимжуулсан 379 бүртгэл, улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн 10 гэрчилгээг хүчингүйд тооцсон, үл хөдлөх эд хөрөнгийг давхардуулж бүртгэсэн 1

бүртгэлийг хүчингүй болгосон хяналтын байцаагчийн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 188 бүртгэлд хяналт тавьж, 48 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан. Бүртгэлийн хувийн хэргийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай тулган шалгахад хуулийн этгээдийн эрх шилжүүлсэн өөрчлөлт мэдээллийн санд ороогүй, үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигч гишүүний мэдээллийг оруулаагүй орхигдуулсан зэрэг зөрчил илэрснийг арилгаж шийдвэрлэлээ.

Архивын лавлагаа олгосон 409 бүртгэлд хяналт тавьж, шалгалтаар илэрсэн 24 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан.

Иргэдээс ирүүлсэн 46 өргөдөл, материалыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 45 өргөдлийн дагуу холбогдох бүртгэлийг архивын эх нотлох баримттай тулган шалгаж, зөрчлийг арилгах дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн. 1 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлсэн байна.

Улсын бүртгэлийн зөрчил арилгах, засвар өөрчлөлт оруулах, бүртгэл хүчингүй болгох, регистрийн дугаар өөрчлөх, бүртгэл сэргээн тогтоосон 124 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр 351 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 106, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 5, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 13 дүгнэлт гаргаж, Хяналт шалгалтын газраар хянуулан, биелэлтийг хангуулж ажилласан.

Бүртгэл хийх явцад зөрчил гаргасан 10 бүртгэлд холбогдох бүртгэгчээс тайлбар авч, зөрчлийг арилгасан.

Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 5 хоног тутамд хүргүүлэн хянуулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 248 хүнд нийт 4 995 000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн удирдамжийн дагуу иргэн, хуулийн этгээдийн иргэний үнэмлэх, энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж үйлчилгээ үзүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт шалгалт хийлээ.

Шалгалтыг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэсэн. Шалгалтад тус аймгийн төв буюу Есөнбулаг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 6 нэрийн 25 дэлгүүр, 8 нэрийн 74 дэлгүүр, зочид буудал 7, барьцаалан зээлдүүлэх 10 газрыг хамруулав.

Зоогийн газар, гуанз, цайны газар, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Мөст-Алтай ХХК-ийн үйлчилгээний ажилтанд одоогоос 6 сарын өмнө барьцаанд тавьсан гэх 5 иргэний гадаад паспорт, иргэний үнэмлэх байсныг тэмдэглэл, акт үйлдэн хураан авсан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын баталсан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх” ажлыг хэрэгжүүлж, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянах төлөвлөгөөт шалгалтыг 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар тус аймаг дахь УБХ-ийн сумдын болон иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарын 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн бүртгэлийн эх нотлох баримт бичиг улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэгдсэн эсэхийг шалгав.

Тайлангийн хугацаанд бүртгэсэн 1252 бүртгэл улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нотлох баримтууд бүрэн цахимжсан байв. Шалгалтын явцад илэрсэн бүртгэлийн нотлох баримтыг сольж цахимжуулсан, нотлох баримтын зураг нээгдэхгүй байгаа 8 зөрчлийг арилгахаар ахлах бүртгэгч нарт зөрчлийн тэмдэглэлийг хүргүүлж ажиллалаа

Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 1 хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж, шүүхэд хариу тайлбар бичгээр өгч, захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд танхимаар, давах шатны шүүх хуралдаанд онлайнаар оролцсон. Хоёр шатны шүүх хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хяналт шалгалтын ажлын статистик тоон мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

УБЕГ-аас зохион байгуулсан Хяналтын улсын байцаагч нарын сургалтанд онлайнаар 3 удаа хамрагдсан.

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:

2022 онд 120.0 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх бөгөөд 11 сарын 30-ны өдрийн байдлаар бүртгэлийн үйлчилгээний орлого 93 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 77,5% -тай байна.

Төсөв, санхүү

2022 оны 11-р сарын байдлаар 555,416,200.00 төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, 464,703,243.00 төгрөгийг зориулалтын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж ажилласан. Мөн 2022 оны төрийн хэмнэлтийн тухай хууль болон УБЕГ-аас өгсөн зөвлөмжийн мөрдөн ажиллаж байна.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт /2022 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	555,416,200.00	555,416,200.00	0.00
Улсын төсвөөс санхүүжих	555,416,200.00	555,416,200.00	0.00
II. НИЙТ УРСГАЛ ЗАРЛАГЫН ДҮН	555,416,200.00	464,703,243.00	90,712,957.00
Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	405,960,300.00	395,662,324.00	10,297,976.00
Үндсэн цалин	344,485,700.00	312,644,656.00	31,841,044.00
Нэмэгдэл, урамшуулал	52,762,600.00	75,888,914.00	-23,126,314.00
Унаа хоолны хөнгөлөлт	8,712,000.00	7,128,754.00	1,583,246.00
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	49,364,200.00	48,798,377.00	565,823.00
Тэтгэврийн даатгал	34,241,400.00	33,675,577.00	565,823.00
Тэтгэмжийн даатгал	3,780,700.00	3,780,700.00	0.00
ҮОМШӨ-ний даатгал	3,025,000.00	3,025,000.00	0.00
Ажилгүйдлийн даатгал	755,700.00	755,700.00	0.00
Эрүүл мэндийн даатгал	7,561,400.00	7,561,400.00	0.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,509,300.00	6,509,300.00	0.00
Гэрэл цахилгаан	0	0	0.00
Түлш, халаалт	509,900.00	486,228.00	23,672.00
Цэвэр, бохир ус	0	0	0.00

Байрны түрээс	5,999,400.00	6,023,072.00	-23,672.00
Хангамж, бараа материалын зардал	16,921,100.00	10,254,150.00	6,666,950.00
Бичиг хэрэг	8,303,400.00	6,254,500.00	2,048,900.00
Тээвэр (шатахуун)	2,597,100.00	670,000.00	1,927,100.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,216,200.00	1,472,350.00	743,850.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,200.00	280,000.00	-231,800.00
Бага үнэтэй түргэн элэгдэх, эд ахуйн зүйлс	3,756,200.00	1,577,300.00	2,178,900.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,975,800.00	290,000.00	1,685,800.00
Багаж техник хэрэгсэл	1,492,200.00	0	1,492,200.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,500.00	32500	0.00
Урсгал засвар	451,100.00	257500	193,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	72,963,900.00	2,708,592.00	70,255,308.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	72,209,500.00	2,235,700.00	69,973,800.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	280,000.00	0	280,000.00
Даатгалын үйлчилгээ	241,900.00	241,900.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	188,500.00	186,992.00	1,508.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	731,600.00	480,500.00	251,100.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	731,600.00	480,500.00	251,100.00
Татаас ба урсгал шилжүүлэг	990,000.00	0	990,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	990,000.00		990,000.00
Мөнгөн хөрөнгийн 2022 оны 11 сарын 30-ний үлдэгдэл			90,712,957.00

Өглөг, авлагын талаар:

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд баталсан төсвийн хуваарийн дагуу явж байгаа боловч зарим зардлуудад хуваарилсан төсөв хүрэлцэхгүй байсан учир тооцоо, судалгаа гаргаж УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт сар бүр хүргүүлэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан зарим зардлуудыг өөр эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх ажлуудыг хийсэн.

2022.11.30-ны өдрийн байдлаар Байрны түрээсийн өглөг 355,553.00 төгрөг, түлш халаалтын зардлын өглөг 81,038.00 төгрөг, нийт 436,591.00 төгрөгийн өглөгтэй, ямар нэгэн авлага үүсээгүй байна.

Нэмэлт санхүүжилтын талаар:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн аяны хүрээнд тус хэлтэс нь тэргүүн байр эзэлсэн тул "Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал"-аас 1,000,000.00 төгрөгийн дэмжлэг олгосон.

Аудит, хяналт шалгалтын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал, НББОУС, холбогдох хууль тогтоомж, заавар, журам мөрдөж ажилласан байдал

Санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор тус хэлтэс нь Говь-Алтай аймгийн Төрийн аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж "ЗӨРЧИЛГҮЙ" гэсэн дүгнэлттэй гарсан. Аудитын газраас өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг бүрэн гаргаж 2022.04.08-ны өдрийн №341 тоот албан бичгээр Төрийн аудитын газар болон УБЕГ газарт хүргүүлсэн.

Тайлан мэдээ

2022 оны 11-р сарын байдлаар тус хэлтэс сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Үүнд:

1. Тус хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сарын бүрийн 2-ны өдрийн дотор Төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.
2. Үнэт цаасны тайлан мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч Ц.Ганчимэгт ts.ganchimeg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.
3. 2022 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.
4. Тус хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны дотор бэлтгэн гаргаж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.
5. 1,2,3-р улирлын ХХОАТ-н тайланг гарган дараа сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

Төсвийн ил тод нээлттэй байх зарчим, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил

Байгууллагын үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг хэлтсийн байрны мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

Шилэн дансны мэдээллийг 11-р сарын 30-ны байдлаар 133 мэдээллийг хугацаанд нь оруулсан, хугацаа хоцорсон болон огт оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд 2021 оны 4-р улирал, 2022 оны 1,2,3-р улирлын мэдээллийг хугацаанд нь илгээсэн.

Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт.

2022 оны эхэнд барилга, авто машин, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамж гэсэн 5-н бүлгийн 371,747,856.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2022.11.30-ны байдлаар 398,486,702.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

ТӨБЗГазрын 2022.01.20-ны өдрийн 08 тоот тогтоолоор 7,500,000.00 төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогод авсан.

ТӨБЗГазрын 2022.01.20-ны өдрийн 13 тоот тогтоолоор 11,100,000.00 төгрөгийг суудлын авто машиныг орлогод бүртгэсэн.

ТӨБЗГазрын 2022.01.25-ны өдрийн А-1/163 тоот албан бичгийн дагуу 6,500,000.00 төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогод бүртгэсэн.

Тус хэлтсийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022.10.12-ны өдрийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн УБЕГазрын санхүү аж ахуйн хэлтэст 2022.10.13-ны өдрийн 895 тоот албан бичгээр 8,453,000.00 төгрөгийн актлах хөрөнгийн жагсаалтыг хүргүүлсэн.

Тус хэлтэс нь орон сууцны 3 өрөө байртай ба одоогоор ямар нэг үйл ажиллагаа явагдаагүй байна.

Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.

Мөн хэлтсийн даргын 2022 оны А/12 тоот тушаалаар эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж үндсэн хөрөнгийн тооллогыг хийж дуусгаж, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын сайтанд байрлах төрийн өмчийн тооллогын системд тайлан мэдээ болон өмчийн бүртгэлийн хийсэн.

ТӨБЗГазраас 2021 оны төрийн өмч эзэмшүүлэх гэрээг 96% А үнэлгээтэй дүгнэгдсэн.

Бараа материалын бүртгэл хөтлөлт, тайлагнасан байдал

- Няравын болон улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг хугацаанд гаргуулж нярваар нэгтгүүлэн тогтмол хянаж ажилладаг ба Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдүүлэн хяналтын улсын байцаагчаар хүчингүй болгуулан ажиллаж байна.

Мөн 2022.05.17-нд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 2021 оны 10-р сараас 2022 оны 04-р сарын хооронд улсын бүртгэгч нарын хүчингүй болгосон үнэт цаас, маягтыг акталж, устгах талаар хэлэлцэж тус зөвлөлийн хурлын 2022.05.17-ны өдрийн №02 тоот дүгнэлтээр нийт 12 нэр төрлийн 200 ширхэг 39,395.50 төгрөгийн үнэт цаас маягтыг хүчингүй болгож, хэлтсийн даргын 2022 оны А/10 тоот тушаалаар акталж, данснаас хасах шийдвэрийн дагуу нягтлан бодох бүртгэлд тусгасан.

- Аж ахуйн материал, бичиг хэрэг, бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа материалын тайланг сар бүр нярваар гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

ХЯНАСАН:

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.ЧҮЛТЭМЖАМЦ

ТАЙЛАН БИЧСЭН:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН Э.БААТАРСҮРЭН